ERP СИСТЕМИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН МОДУЛЬ

# ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН СУДАЛГАА ХИЙХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Сургалт, дэмжлэгийн баг
2024 он

# ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН СУДАЛГАА ХИЙХ ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

1. Зах зээлийн үнийн судалгаа хийх хэрэглэгч нь ERP системийн Худалдан авалтын модулийн **Бараа** цэсийн **Үнэ судлагдах бараа** дэд цэсээр ороход үнэ судлагдах барааны жагсаалт харагдана. Зах зээлийн үнэ судлагдаагүй барааны төлөв нь **Хуваарилах** төлөвтэй байна.




*Зураг 1. Зах зээлийн үнэ судлагдах барааны жагсаалт*

2. Зах зээлийн үнэ судлагдах барааг судалгааны мэргэжилтэнд хуваарилах эрх бүхий хэрэглэгч нь **Бараа** цэсийн **Үнэ судлагдах бараа** дэд цэсээр орж жагсаалтаас нэг болон хэд хэдэн барааг сонгож дэлгэцийн гол хэсэгт байрлах **Хуваарилах** товчийг дарж ажилтанд хуваарилалтыг хийж болно. **Хуваарилах** товчийг дарснаар дараах цонх гарч ирэх бөгөөд хуваарилахаар сонгосон бараануудын зах зээлийн үнийн судалгааг хийх мэргэжилтний нэрийг сонгож өгч **Хуваарилах** товчийг дарснаар тухайн судалгааны мэргэжилтэнд хуваарилагдан очно.




*Зураг 2. Хуваарилах эрх бүхий хэрэглэгч үнэ судлагдах бараанаас сонгож хуваарилалт хийх*




*Зураг 3. Судалгааны мэргэжилтэнд хуваарилах цонх*

3. *Барааг өөр мэргэжилтнээр үнийн судалгаа хийлгэхээр бол **хуваарилагдсан** төлөвтэй барааг дахин хуваарилна.*




*Зураг 4. Судалгаа хийх мэргэжилтэнг солих буюу дахин хуваарилах цонх*

4. Хайлтын системийг ашиглан зах зээлийн үнэ судлагдах болон хуваарилагдсан төрлөөр хайлт хийж харах боломжтой.
   - **Хуваарилагдсан:** Мэргэжилтэнд хуваарилагдсан барааг харуулна
   - **Хуваарилаагүй**:Үнийн судалгаа хийгдээгүй, удирдлагаас хуваарилах шаардлагатай барааны жагсаалтыг харуулна
   - **Судлаж байна**: Үнийн судалгаа хийхээр эхлүүлсэн барааг харуулна
   - **Судалсан:** Үнийн судалгаа хийж дуусан барааг харуулна




*Зураг 5. Хайлтын багаж ашиглан өөрт шаардлагатай төрлөөр харах*

5. Үнийн судалгаа хийх мэргэжилтэн нь өөрт хуваарилагдсан үнэ судлах барааны жагсаалтыг харахын тулд Худалдан авалтын модулиар орж **Каталог** дэд цэсийн **Үнэ судлагдах бараа** цэсээр орж Хайлтын багаж дээр **Судлагдаж байгаа** шүүлтүүрийг сонгож харна.




*Зураг 6.Үнийн судалгаа хийх мэргэжилтэн судалгаа хийж байгаа барааны жагсаалтыг хайлтын багаж ашиглан гаргах*

6. Үнийн судалгааг бүртгэхдээ үнэ судлах барааны жагсаалтаас нэг болон олноор сонгож **Үнийн судалгаа хийх** товч дээр дарж судалгаа оруулах бүртгэлийн цонхыг нээнэ.




*Зураг 7. Хуваарилагдсан барааны жагсаалтаас сонгож үнийн судалгаа хийх*

Үнийн судалгаа оруулахдаа Нийлүүлэгч талбараас хайлт хийж тухайн нийлүүлэгч байгаа бол сонгож байхгүй бол **Create** төлөвөөр үүсгэх боломжтой. Нийлүүлэгчээс авсан үнийг тухайн нэгж үнэ хэсэгт оруулж өгнө.




*Зураг 8. Нийлүүлэгчээс авсан үнэ оруулах цонх*

Нийлүүлэгчээс авсан үнээ тухайн барааны **Нэгж үнэ** хэсэгт оруулж үүлэн дүрсээр хадгална.




*Зураг 9.Үнийн судалгаа оруулж хадгалах*

Хэрвээ үнийн судалгааг өөр нийлүүлэгчээс авах бол тухайн байгууллага эсвэл хувь хүнд и-мэйл илгээж үнийн санал авах боломжтой.




*Зураг 10. И-мэйлээр үнийн санал авах*

Олон байгууллагаас үнийн судалгаа авсан бол Хувилбарууд цонхны Альтернатив хувилбар үүсгэх дээр дарж дахин нийлүүлэгч оруулж өгөх боломжтой.




*Зураг 11. Хувилбарт үнийн санал оруулах нийлүүлэгч нэмэх*




*Зураг 12. Үнийн санал олон байгууллагаас авсан түүх*

Үнийн судалгааг нийлүүлэгчээс авсны дараа судалгаа бүрийг **Дууслаа** төлөвт шилжүүлэх хэрэгтэй.




*Зураг 13. Үнийн судалгааг дуусгах*



| Нийлүүлэгч | Лавлагаа | Нийт | Төлөв |
|---|---|---|---|
| Эрдэнэт үйлдвэр | PR (No Vendor) | 62'992'604.93 | Дууслаа |
| голмос тех ххк | PR ( голмос тех ххк ) | 42'060'000.00 | Дууслаа |

*Зураг 14. Үнийн судалгаа дууссан төлөв*

Дууссан төлөвт шилжсэний дараа **Бараа харьцуулах мөр** дээр дарж **Үнийн хүсэлтийн бүтээгдэхүүнийг харьцуулах** цонхыг нээнэ. Гарч ирэх харьцуулсан жагсаалтаас тухайн барааг аль нийлүүлэгч байгууллагын эсвэл хувь хүний үнийг үндсэн үнэ болгохын тулд Сонго гэсэн төлөвийг идэвхтэй болгоно. Жагсаалт дээр сонгогдсон нийлүүлэгч байгууллагын үнийн хүсэлт ногоон өнгөтэй харагдана.




| Бараа | Нийлүүлэ... | Лавлагаа | Хүсэлтийн төлөв | Дэлгэрэнгүй | Тоо хэмжээ | Төсвийн ү... | Нийт | Вал... | Төлөв | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Маркер арилдаггүй усны хамгаалалттай улаан (2) | | | | | 1'000.00 | 5'976.00 | 2'988'000.00 | | | |
| Маркер арилдаггүй усны ... | BSB XXK | PR ( BSB XXK ) | Дууслаа | | 500.00 | 2'978.00 | 1'489'000.00 ₮ | MNT | | |
| Маркер арилдаггүй усны ... | Номин XXK | PR ( Номин XXK ) | Дууслаа | | 500.00 | 2'998.00 | 1'499'000.00 ₮ | MNT | | |
| Маркер арилдаггүй усны хамгаалалттай хар (2) | | | | | 3'000.00 | 5'976.00 | 8'964'000.00 | | | |
| Маркер арилдаггүй усны ... | BSB XXK | PR ( BSB XXK ) | Дууслаа | | 1'500.00 | 2'978.00 | 4'467'000.00 ₮ | MNT | Байхгүй | Сонго |
| Маркер арилдаггүй усны ... | Номин XXK | PR ( Номин XXK ) | Дууслаа | | 1'500.00 | 2'998.00 | 4'497'000.00 ₮ | MNT | Байхгүй | Сонго |
| Маркер арилдаггүй усны хамгаалалттай хөх (2) | | | | | 1'000.00 | 5'976.00 | 2'988'000.00 | | | |
| Маркер арилдаггүй усны ... | BSB XXK | PR ( BSB XXK ) | Дууслаа | | 500.00 | 2'978.00 | 1'489'000.00 ₮ | MNT | Байхгүй | Сонго |
| Маркер арилдаггүй усны ... | Номин XXK | PR ( Номин XXK ) | Дууслаа | | 500.00 | 2'998.00 | 1'499'000.00 ₮ | MNT | Байхгүй | Сонго |

*Зураг 15. Үнийн судалгаа дууссан төлөвт орсны дараа үндсэн үнэ болгох сонголт хийх төлөв, Жагсаалтын мөр дээр сонгогдсон нийлүүлэгч байгууллага өнгөөр ялгагдаж харагдана*




| Төлөв | Бараа | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Үүсгэсэн огноо |
|---|---|---|---|---|
| Судалсан | Өрмийн чөмгөн дээжийн хуванцар хайрцаг /HQ/ | 8'000.00 | 5'000.00 ₮ | 2024-06-14 13:12:35 |
| Судалсан | Өрмийн чөмгөн дээжийн хуванцар хайрцаг /PQ/ | 4'000.00 | 0.00 ₮ | 2024-06-14 13:14:48 |
| Судалсан | Гулууз дээжийн хуванцар шошго NQ | 8'000.00 | 5'500.00 ₮ | 2024-06-14 13:04:53 |
| Судлах | Нэг удаагийн хамгаалалтын комбинзон Хятад цагаан | 100.00 | 28'040.00 ₮ | 2024-06-20 09:45:19 |
| Судлах | Чулуу зүсэгч алмазан хөрөөний ир | 30.00 | 1'936'512.50 ₮ | 2024-06-20 12:11:35 |

*Зураг 16. Үнэ судлагдсан төлөв*

*Сургалт, дэмжлэгийн баг*